

## **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Хүн төрөлхтөн нийтээр хүлээн зөвшөөрсөн анхны баримт бичиг бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталснаас хойш эрүүдэн шүүхийг олон улсад хориглосон зохицуулалттай. Тодруулбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй<sup>1</sup>” гэж заасан байдаг. Энэ үүднээс “Эрүү шүүлтээс анgid байх эрх” нь хүний жам ёсны эрх бөгөөд ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрх юм.

Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейгээс 1975 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталснаар эрүү шүүлт болон хүнлэг бус, хэрцгий, доромжлох хандлагаас анgid байх эрхийг олон улсын түвшинд баталгаажуулах суурийг тавьсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейгээс 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 39/46 дугаар тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцыг баталж, 2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хурал соёрхон баталсан. Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тавиндолдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт Протоколыг баталж, 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хурал соёрхон баталсан байна.

Энэхүү протоколын зорилго нь Олон улсын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний бие даасан байгууллага хараат бусаар ажиллах боломжийг олгох буюу Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бий болгоход оршино.

Протоколын 3 дугаар зүйлд зааснаар оролцогч улс бүр үндэсний түвшинд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрх хязгаарласан газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага

---

<sup>1</sup> [ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ \(legalinfo.mn\)](http://legalinfo.mn)

байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүргийг хуулиараа хүлээхээр зохицуулсан байна.

Монгол Улс НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд нэгдэж орсноос хойш багагүй хугацаа өнгөрч байгаа ба НҮБ-ын Хүний эрхийн холбогдох хороодоос Монгол Улсын Эрүүдэн шүүхийн эсрэг Үндэсний урьдчилан сэргийлэх хараат бус бие даасан механизмыг байгуулах асуудлаар удаа дараа зөвлөмж өгч ирсэн<sup>2</sup>.

Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколыг /ЭШЭКНП/ соёрхон батлах тухай хуулийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр баталснаар 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан билээ.

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.12-т “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, тус хуулийн Долоодугаар бүлэгт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг тусгайлан зохицуулахаар хуульчилсан. Тус хуулийн зохицуулалтын хүрээнд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн хэрэгжүүлэхээр зааж, гишүүний бүрэн эрх, хараат бусаар ажиллах

---

<sup>2</sup> “Өөрийн харьяаллын нутаг дэвсгэрт байгаа аливаа иргэний эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрхийг хамгаалах, мөн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой олон тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэл”-үүд, “Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын хоёрдугаар илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж” (2016), “НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан Дэд хороо Монгол Улсад 2017 оны 09 сарын 11-ээс 20-ны өдрүүдэд хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан зөвлөмжүүд” (2017), НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн Ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас өгсөн зөвлөмжүүд” зэрэг болно.

хууль зүйн болон эдийн засгийн баталгааг хангах, чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж, алба хаагчдын хараат бусаар ажиллах асуудлыг хуульчлан зохицуулсан.

Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр баталсан “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн оид зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай холбоотой зохицуулалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод нийцэж байгаа эсэх талаар болон хуулийн холбогдох зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, танилцуулахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/, Хүний эрхийн дэд хороо /Ц.Мөнхцэцэг/-нд даалгасан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны талаар хараат бус судлаачдын багийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаагаар эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ нь холбогдох конвенц болон Нэмэлт протоколын шаардлагад бүрэн нийцээгүй, ЭШУС үндэсний ажиллагааны чиг үүргээ олон улсын эрх зүйн актад тусгагдсаны дагуу хараат бусаар, бие даасан үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, үл ойлгогдох байдал үүсгэхүйц, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаа нь конвенцод заасан хяналт шинжилгээ хийх газрыг хязгаарласан, хүний нөөц, санхүү болон үйл ажиллагааны бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг олгохгүй, үйл ойлгогдох нөхцөл байдлыг үүсгэхүйц, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл учирч байгаа нь тогтоогджээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг 1, 3, 6, 7, 8 дугаар бүлгийн 22 заалтаар үнэлбэл Зорилгод хүрсэн байдал нь 50 хувь, Практикт нийцэж буй байдал нь 22.7 хувь байна.

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж; Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 77-д “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж; Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дөрөв дэх хэсгийн “Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэчлэл”-ийн 4.4.12-д “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг

төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.” гэж тус тус тусгасан.

Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл”, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланд дурдсанаар сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд эрүү шүүлт тулган мэдүүлэг авах, түүнийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх, хүний эрхийг зөрчих асуудал гарсаар байгааг тодорхойлсон байна. Ялангуяа цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунган эрүү шүүлтэд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

“Эрүүдэн шүүх” үйлдлийг Эрүүгийн хуульд 4 төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд оруулсан нь гэмт хэргийн зүйлчлэлд тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа тул Конвенцын дагуу “Эрүүдэн шүүх” гэмт хэргийг оновчтой тодорхойлж, ялыг чангатгах саналыг судлаачид гаргасан байна.<sup>3</sup>

Түүнчлэн 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн агуулга нь ЭШЭК-ийн 1 дүгээр зүйлд “эрүү шүүлт гэж ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие маход, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдэл” гэснийг бүрэн агуулаагүй байна.

Иймд эрүү шүүлт тулгах эсхүл гутаан доромжлох, шахалт дарамт үзүүлэх сэдэлт, зорилго нь гуравдагч этгээд ч эрүүгийн хариуцлага хүлээхээр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Мөн түүнчлэн практик нөхцөл байдлыг тодруулбал Монгол Улсын хэмжээнд мөрдөн шалгах ажиллагааны явцад эрүү шүүлт тулгах гомдол, мэдээлэл буурахгүй байсаар байна.

Прокурорын мэдээлэлд<sup>4</sup> 2017 оны сүүлийн хагас жил, 2018-2022 оны байдлаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 13.9 /Хууль бусаар баривчлах/, 14.1 /Ялгаварлан гадуурхах/, 21.12 /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэргүүдэд нийт 385 гомдол, мэдээлэл бүртгэгдэн 471 хүн шалгагдсанаас 359 гомдол, мэдээлэл буюу 93,2 %, 449 хүн буюу 95,3 % нь тус тус цагдаагийн алба хаагчтай холбоотой байна.

Цагдаагийн алба хаагчдад холбогдуулан 2017 оны хагас жилийн байдлаар 5 гомдол, мэдээлэлд 5, 2018 онд 33 гомдол, мэдээлэлд 47, 2019 онд 74 гомдол, мэдээлэлд 96, 2020 онд 86 гомдол, мэдээлэлд 115, 2021 онд 86 гомдол, мэдээлэлд 99, 2022 онд 75 гомдол, мэдээлэлд 87 алба хаагч тус бүрд дээрх гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг иргэн, албан тушаалтнаас гаргажээ.

<sup>3</sup> “Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас ангид байх эрхийн хэрэгжилт” (Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум, 2019.10.03).

<sup>4</sup> УЕП-ын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 4/1751,

2017 оны сүүлийн хагас жилийн байдлаар 6 хэрэг бүртгэлтийн хэрэгт 9, 2018 онд 28 хэрэг бүртгэлтийн хэрэгт 33, 2019 онд 46 хэрэг бүртгэлтийн хэрэгт 55, 2020 онд 51 хэрэг бүртгэлтийн хэрэгт 67, 2021 онд 26 хэрэг бүртгэлтийн хэрэгт 35, 2022 онд 22 хэрэг бүртгэлтийн хэрэгт 27 цагдаагийн алба хаагч шалгагджээ.

Прокурорын байгууллагаас 2018 онд 1 хүнтэй 1, 2020 онд 1 хүнтэй 1, 2021 онд 3 хүнтэй 2, 2022 онд 2 хүнтэй 1 эрүүгийн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгосны зэрэгцээ 2018, 2019 онд тус бүр 1 хүнтэй 1, 2020 онд 7 хүнтэй 4, 2021 онд 4 хүнтэй 2, 2022 онд 7 хүнтэй 5 эрүүгийн хэргүүдэд яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байх бөгөөд 2022 онд өмнөх оноос 2,5 дахин өсжээ<sup>5</sup>.

Иймд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүnlэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, Монгол Улсын Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн чухлыг эргэн санаж, НҮБ-ын хүний эрхийн механизм, тэдгээрийн хараат бус шинжээч, ажлын хэсгийн зөвлөмжийг гарцаагүй хэрэгжүүлэх шаардлагатайг анхаарч, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад шинээр бүрэлдэн бий болж байгаа эмзэг цаг үе гэдгийг мэдэрч, маш олон хаалттай хаалганы цаана байгаа хүмүүсийн эрхийг хамгаалахыг чухалчлан, хууль тогтоогч, ОУБ, ТББ, хүний эрхийн болон нийгмийн зүтгэлтэн, судлаач, иргэдийн оролцоо, дэмжлэг нэн хэрэгтэй байгааг тодотгон, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд заасны дагуу хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл бололцоог хангах арга хэмжээг Монгол Улсын ХЭҮК-ын тухай хууль, Эрүүгийн хууль, бусад хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хууль 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан 8 бүлэг 41 зүйлтэй. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ЭШЭК-ын Нэмэлт протоколд нийцүүлэн нэмэлт оруулах, зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах, уг нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль болон зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тооцож байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

1. Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь иргэн бүрийн жам ёсны болоод бусад эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, хоорондоо харилцан уялдаатай. Энэ тогтолцоонд хүний эрүү шүүлт, хүnlэг бус харьцаа, доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх жам ёсны, ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрхийг хамгаалах, хангах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эрхэлдэг тогтолцоо буюу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг Эрүү шүүлтээс урьдчилан

<sup>5</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайлан. 2023 он. Уб.

сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр төлөөлүүлэн багтааж Монгол Улсын Хүний эрхийг хамгаалах тогтолцоог бүрэн бэхжүүлэхээр тусгалаа.

2. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2."Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх" гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүnlэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг" гэж заасны дагуу ЭШУС үндэсний ажиллагааны төсвийг бүрэн хараат бус байхаар нэг мөр зохицуулах, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэхэд бусад байгууллага, албан тушаалтан шууд нөлөөлөх эрсдэлтэй байдлыг хязгаарлан ЭШЭК-ын нэмэлт протоколд нийцүүлэх шаардлагыг хангахаар зохицууллаа.

Мөн ЭШЭКНП—ын 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт "Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, хөрөнгөөр хангах үүрэг хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлж ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг захиран зарцуулах төсвийн ерөнхийлөн захирагчаар Төсвийн тухай хуульд тодотгох нэмэлтийг тусгалаа.

3. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд туслах чиг үүрэг бүхий орон тооны нэгж ажиллана.", энэ зүйлийн 36.3 дахь хэсэг "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь ... зөвхөн энэ хуулийн 33.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ." гэж тус тус заасан.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт "Комиссын гишүүн болон бусад албан тушаалтан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, оролцохыг хориглоно." гэж хуульчилсан баталгааг хангах зорилгоор ЭШУС нэгжийн даргыг томилж, чөлөөлж байгаа одоогийн зохицуулалтыг дэмжиж, нэгжийн албан хаагчдыг комиссын тамгын газарт харьяалуулахгүй байж, хараат бус байдлыг бүрэн хангахаар тусгалаа.

4. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулиар ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн тангараг өргөх, шаардлага бичих зэрэг эрх зүйн зохицуулалт хуульчлагдаагүй байгааг нэмэлтээр тусгав.

5. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүnlэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколд ЭШУС нэгжийн албан хаагчдад тавигдах шаардлага, шалгуурыг тогтоосны дагуу ЭШУС асуудал эрхэлсэн гишүүн нь ЭШЭК, түүний нэмэлт протоколын 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасан "Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын шинжээчид шаардлагатай ур чадвар, "нэгжийн албан хаагчид тавигдах тусгай шаардлага бүхий журам гаргах эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгаж ЭШУС асуудал эрхэлсэн гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах хэрэгцээ шаардлагыг төсөлд тусгав.

6. Комиссын болон ЭШУС асуудал эрхэлсэн гишүүний хууль зүйн баталгаанд тэдгээрийн ажлын онцгой нөхцөлтэй уялдуулан тээврийн хэрэгслийг нэмэлтээр оруулж үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах үндсийг бэхжүүлэхээр тусгав.

7. Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд дараах асуудлыг тусгана.

А). Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйл буюу Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн зохицуулалтыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод болон одоогийн үүсээд буй практик хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлт тулгах хэлбэрийг өргөжүүлэн зохицуулах;

Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие маход, сэтгэл санааг шаналган зовоосон” гэх байдлаар тодорхойлсон нь өмнөх 2002 оны Эрүүгийн хуульд тодорхойлсан зохицуулалт болсон хэдий ч тайлбар, мэдүүлэг авахаас бусад нотлох ажиллагааны хүрээнд эрүү шүүлт тулгахаас хамгаалж чадаагүй байна.

Тухайн гэмт хэргийг зөвхөн тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор гэж хязгаарласнаас үүдэн бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүү шүүлтийн шинжтэй үйлдлүүд орхигдож байх үндэслэлтэй. Учир нь эрүү шүүлт гэдэг нь тодорхой мэдүүлэг буюу өөр бусад мэдээлэл авах зорилгоор албан тушаалтан болон түүний даалгаснаар сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч буюу шинжээчид зориуд бие маходын болон ёс суртахууны зовлон шаналал учруулсан өргөн хэмжээний үйлдэл бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд бий болж болохоор байна.

Б). Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйл буюу Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн зохицуулалтын хүндрүүлэх бүрэлдэхүүнд “бусдын эрүүл мэндэд хохирол учруулж үйлдсэн” болон “тухайн гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан” гэх үйлдлийг тусган бусад гэмт хэргээс эрүү шүүлт тулгах үйлдлүүдийг хассанаар хуулийн давхардлыг арилгах, цаашлаад ял завших боломжгүй болгох.

2015 оны Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл буюу Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд “бусдын эрүүл мэндэд хохирол учруулж үйлдсэн” болон “тухайн гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан” үйлдлийг хуульчлаагүй нь хуулийн давхардлыг бий болгож байна. Тус үйлдлүүд 10.1 дүгээр зүйл буюу Хүнийг алах, 11.1, 11.4, 11.6 дугаар зүйлүүд буюу хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хүнд учруулах гэмт хэргийн бүрэлдэхүүнд “Эрүүдэн шүүж” гэх томьёоллоор хуульчлагдсан байна.

Энэхүү давхардлыг арилгаж 21.12 дугаар зүйл буюу Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлах нь тухайн гэмт хэргийн хамгаалж буй объект болон субъектив талтай нийцэх бөгөөд одоо үүсээд буй ял завших боломжийг үгүй хийж Эрүү шүүлт тулгах үйлдлийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулан хүний халдашгүй байх эрхийг хангах баталгаа болно. 2002 оны Эрүүгийн хуульд энэхүү үйлдлүүдийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд багтааж тухайн асуудлыг шийдвэрлэсэн байдал.

8. Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг баримтлан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль нь ЭШЭК, түүний нэмэлт протоколд нийцэж байгаа эсэх талаар хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, дүн шинжилгээг хараат бус шинжээчдийн багаар хийлгэсэн.

Үнэлгээгээр одоогийн хэрэгжиж буй хуулийн зүйл заалт нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт Протоколтой уялдаа холбоо муутай, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагаа болон Асуудал хариуцсан гишүүний бүрэн эрх зөрчигдэх, үндэсний урьдчилан сэргийлэх нэгж, түүний нэгж чиг үүргийнхээ хувьд хүний нөөц болон санхүүгийн хараат бус байх нөхцөлөөр бүрэн хангагдаагүй, түүний хэрэгжүүлэх хуулийн хөшүүрэг хангалтгүй, процедур, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхойгүй зэрэг олон хүндрэлтэй асуудлууд байна гэж дүгнэсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гарах санхүүгийн нэмэлт зардал гарахгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан холбогдох аргачлалын дагуу хийсэн болно.

Иймд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт Протоколын үзэл санаанд тулгуурлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үйл ажиллагааг бие даасан хараат бусаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх үүднээс боловсруулсан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг дэмжин шийдвэрлэж өгөхийг хүсье.